



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 6 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 - 31
<hr/>	
<i>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт</i>	8 – 9
<i>2. “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	9 – 11
<i>3. “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	11 – 13
<i>4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	13
<i>5. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн/</i>	13 - 31

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 06-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ц.Сэргэлэн;
Тасалсан: П.Анужин, Ж.Эрдэнэбат.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбаяр, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд уг асуудлыг хаалттай горимоор хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаан 14 цаг 45 минутаас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хаалттай горимоор хэлэлцэв.

Байнгын хорооны хуралдаан 16 цаг 21 минутад нээлттэй горимд шилжин хуралдаан үргэлжлэв.

Б.Энх-Амгалан: 1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ” гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасныг “зөрчсөн байна” гэснийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 10
Бүгд: 10
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжуудыг хэлнэ” гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасныг “зөрчсөн байна” гэснийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 10
Бүгд: 10
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Зам, тээврийн хөгжлийн яамны Хууль зүйн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ё.Жаргалсайхан, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга Э.Мөнхнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооноос гарах хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 16 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны дарга Т.Төрболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Б.Мажигсүрэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Баделхан, Б.Энх-Амгалан, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Б.Баттөмөр, Н.Наранбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 10 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 6 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 41 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанд оролцох ажлын хэсгийн гишүүдийг урья.

Хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу Байнгын хорооны хуралдааны ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг гишүүн чөлөөтэй, Г.Амартүвшин гишүүн чөлөөтэй, П.Анужин гишүүн чөлөөтэй, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн, Б.Батгөмөр гишүүн ирсэн, Х.Баделхан гишүүн ирсэн, С.Батболд гишүүн өвчтэй, Б.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүн ирсэн, Б.Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй, Н.Наранбаатар гишүүн ирсэн, Ц.Сэргэлэн гишүүн өвчтэй, Д.Цогтбаатар гишүүн ирсэн, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн чөлөөтэй.

Ингээд гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Хоёр.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 5 сарын 01-ний өдрөөр мэдүүлсэн.

Гурав.Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Дөрөв.Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээрийн төсөл. Зөвшилцөх. Засгийн газар 2023 оны 5 сарын 15-ны өдөр өргөн ирүүлсэн.

Тав.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 5 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Энэ асуудлыг хэлэлцэх үед асуудлыг танилцуулах Сангийн сайд

Б.Жавхлан хэлэлцээрт орж байгаа учраас асуудлыг тавдугаарт бичүүлж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан учраас энэ асуудлыг тавдугаарт хэлэлцэхээр боллоо.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт

Энэ дээр горимын санал гаргана гэсэн байна уу? Н.Энхболд гишүүн. Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая гэж байна. Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Сая хурал эхлэхээс өмнө бас нууцын зэрэглэлтэй танилцах материалууд бидэнд ирлээ л дээ.

Энэ цэц дээр зүгээр ил явсан гэж ойлгосон. Тэгэхдээ энэ бас ярих юмнууд байх шиг байна. Сонсох.

Энэ цэцийн дүгнэлтийг авах уу, авахгүй гэдгээ ярих учраас бас тодруулах, ярих юмнууд байна. Ялангуяа ийм бичиг ирчхээд бас нэг асуух тодруулах ийм зүйлүүд байгаа учраас яг энэ асуудлаа хаалттай горимоор хэлэлцэх нь зүйтэй гэж горимын санал гаргаж байна. Тийм.

Б.Энх-Амгалан: Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-г заасан хаалттай хэлэлцэхээр хуульд заасан бол

Хэлэлцэх асуудал батлагдлаа. /алх цохив/

Нэгдүгээр асуудал хэлэлцэнэ.

төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.3-д Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасан.

Энэ асуудал бас гүйцэтгэх ажилтай холбоотой ийм асуудлууд байгаа учраас Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

55.6 хувийн саналаар энэ санал хураалт явагдлаа.

Д.Цогтбаатар гишүүний саналыг дэмжсэнд тооцож протоколд бүртгэе.

Ингээд хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.

Х А А Л Т Т А Й (14:45-16:21)

Л.Энх-Амгалан: Одоо санал хураана. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Санал хураалт явуулна.

Нээлттэй болсон уу? Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя. Гишүүд ээ.

Нэг. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан

техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ” гэж заасны “илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасныг “зөрчсөн байна” гэснийг хүлээн авах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Дэмжихгүй. Тийм.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 100 хувийн саналаар энэ саналыг хүлээж авах боломжгүй гэж. Энэ санал дэмжигдсэнгүй.

Хоёрдугаарт, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжуудыг хэлнэ” гэж заасны

Хоёр. “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Дараагийн асуудал. Ажлын хэсэг оруулья.

“Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья.

“илрүүлэх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасныг “зөрчсөн байна” гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 100 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулья.

Дараагийн асуудалдаа орёё. Ажлын хэсэгт баярлалаа.

Ажлын хэсэг оруулаарай. Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Доржийн Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Сүхээгийн Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хууль зүйн хэлтсийн дарга, Чимэддоржийн Мөнхтуяа Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Пүрэвжавын Ганболд Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга.

Ажлын хэсгийн гишүүд байраа эзлээрэй.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт сайдыг урьж байна.
С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая.

Монгол Улс Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод 1989 онд нэгдэн орж Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 162 дахь гишүүн болсноор тус байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудит, хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр, сургалтад хамрагдах, хурал чуулганд оролцох зэргээр олон улсын иргэний нисэхийн үйл хэрэгт оролцсоор ирсэн.

Агаарын хөлгийг бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай 1963 оны Токиогийн конвенцод манай улс 1990 онд нэгдэн орсон.

Агаарын хөлөг түүний дотор байгаа хүмүүс өмч хөрөнгө, хөлгийг бүхээгдэх хэвийн журам, дэглэмд аюул учирч болзошгүй агаарын хөлгийг бүхээгдэх хяналтгүй зан төлөвийн ноцтой байдал, давтамж нэмэгдэж буйтай холбогдуулан түүнийг хязгаарлах, хэвийн журам, дэглэмийг сэргээн тогтооход харилцан туслалцаа үзүүлэх олон улсын хэм хэмжээг бэхжүүлэх зорилгоор Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2014 оны Нисэхийн аюулгүй байдлын

дипломат бага хурлаас дээрх конвенцын нэмэлт протоколыг баталсан байна.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц нэмэлт протоколоор агаарын хөлгийн бүхээгдэх гэмт хэргийн харьяаллыг илүү өргөжүүлсэн бөгөөд хэв журам зөрчсөн гэм хорыг арилгахтай холбоотой нөхөн төлбөрийн зохицуулалтыг нэмж тусгажээ.

Энэхүү протокол нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 36 улс гарын үсэг зурж, 17 улс соёрхон баталж, 26 улс нэгдэн орж, 2 улс хүлээн зөвшөөрчээ.

Агаарын тээврийг либералчилж, нислэгийн тоо, чиглэлийг эрчимтэй нэмэгдүүлж байгаа энэ үед манай улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт түвшинг олон улсын шинэчлэн сайжруулж байгаа стандарт шаардлагад нийцүүлэх, агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй сайжруулах шаардлагатай болоод байна.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү?

Асуулт асуух гишүүд гишүүн алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байвал нэрээ өгнө үү?

Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт эхэлбэ. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн

Гурав. “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Олон улсын тээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээрийн төсөл зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүд түрүүн танилцуулсан ажлын хэсгийн гишүүд байна.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

Нийт 10 гишүүн хуралдаанд оролцоноос 8 гишүүн санал өгч, 80.0 хувийн саналаар энэ санал батлагдлаа.

Санал хураалтын дүнг танилцуулсан.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулья.

Дараагийн асуудалдаа орёе.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 1993 оноос эхлэн олон улсын авто тээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Казакстан, Украин, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Турк, Киргиз, Беларусь, Латви, Унгар, Литва, Словен, Польш улсуудтай байгуулсан.

Тус яамны зүгээс олон улсын хэмжээнд авто тээврийн салбарыг хөгжүүлэх гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, тээврийн үйлчилгээг хөнгөвчлөх, хил гаалийн хяналтын үйл ажиллагааг хялбаршуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ихээхэн анхаарч ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд “Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг 2021 онд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2021 оны 03 дугаар сард 18 дугаар тэмдэглэл гарсан бөгөөд хоёр улсын хооронд авто тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг солилцож, тээвэрлэлтийн холбогдох хууль тогтоомжийн дагуу эхлүүлсэн.

Хэлэлцээрийн төслийн саналын зөрүүтэй асуудлыг хоёр талд эцэслэн хэлэлцээрт гарын үсэг зурахад бэлэн болоод байна.

Хэлэлцээрийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт болон Словакийн талаас хэлэлцээрийг соёрхон баталснаар хүчин төгөлдөр болохтой холбогдуулан Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Сангийн яамнаас Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлж соёрхон батлуулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг ирүүлсэн.

Үүний дагуу “Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон тухай Засгийн газрын хуралдааны 19 дүгээр тэмдэглэл гарсан болно.

Үүнтэй холбогдуулан хэлэлцээрийн асуудлаар Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөхөөр хэлэлцээрийн төсөл болон бусад шийдвэрийн төсөл, холбогдох танилцуулгыг танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайдад баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдэд нэмж ирсэн гишүүдийг танилцуулж протоколд тэмдэглүүлье.

Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ёндонсүрэнгийн Жаргалсайхан Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Энхтайваны Мөнхнасан Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга.

Уг хэлэлцсэн асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Уг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулъя. “Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

10 гишүүн санал хураалтад оролцож, 8 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар энэ асуудал дэмжигдлээ.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний төхөөрөмж ажиллаагүй учраас протоколд дэмжсэнээр тэмдэглэе. /алх цохив/

Уг асуудлыг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Дараагийн асуудалдаа орёё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын дарга 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 96 дугаар захирамжаараа Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлыг дарааллын товйг тогтоосон байна.

Уг захирамжийг үндэслэн Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооноос энэ 6 сард хэлэлцэх тухай асуудлын цаглаварыг баталсан тогтоол гаргах юм.

Байнгын хорооны гишүүдэд тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя гишүүд ээ.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтын дүнг танилцуулъя.

Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар уг тогтоол дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа орёё.

Тав. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр, 2022-2023 оны зээлийн

төлөвлөгөөг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 5 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Уг асуудлыг хэлэлцье. Ажлын хэсгийг оруулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн, Санжаагийн Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Цэндгомбо овогтой Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зориг овогтой Мөнх-Оргил Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чадраабалын Сугармаа Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бандийн Гантулга Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга, Түмэндэмбэрэлийн Төрболд Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны дарга.

Ажлын хэсгийн гишүүд байраа эзлээрэй. Ажлын хэсгийн гишүүд байраа эзэлье.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр, 2022-2023 оны зээлийн төлөвлөгөөг соёрхон батлах тухай хуулийн төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын

гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Сангийн сайдын микрофоныг өгье. Б.Жавхлан сайд танилцуулгаа хийе.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хороон дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын хамгийн том түнш байгууллагын нэг болох Азийн хөгжлийн банктай ирэх жилүүдэд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор тус банкнаас Монгол Улсад хуваарилж болох 655.0 сая ам.долларын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг хийлээ.

Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төслийг Улсын Их Хурлын Төсөв, Эдийн засаг болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулж хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгох Ерөнхий сайдын захирамжийн төслийг зөвшилцөн дэмжсэнээр хоёр талаас гарын үсэг зурсан болно.

Азийн хөгжлийн банктай байгуулах Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь олон улсын гэрээ бөгөөд Улсын Их Хурлаар зайлшгүй соёрхон батлах шаардлагатай тул ийнхүү хуулийн төслийг боловсруулж оруулж ирж байна.

Улсын Их Хурлаар соёрхон батлуулснаар хөтөлбөрийн эх үүсвэрийг заавал авч ашиглах үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь зээлийн гэрээ биш юм.

Харин хөтөлбөрийг Улсын Их Хурлаас хоёрхон баталсан тохиолдолд Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг зээлийн

гэрээ хэлэлцээрийг цаашид судалгаа нээгдэнэ гэсэн үг.

Хөтөлбөрт гарын үсэг зурснаас хойших хугацаанд дараах төсөл, хөтөлбөрийн зээлүүдийн яриа хэлэлцээг Азийн хөгжлийн банкттай эхлүүлэн бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.

Үүнд, төсвийн дэмжлэгийн хэлбэрээр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 200.0 орчим сая ам.доллар. Үүнд:

-Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлогын арга хэмжээг дэмжих төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 100.0 сая ам.доллар,

-Төсөв, санхүү эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 100.0 сая ам.доллар.

-“Шинэ сэргэлтийн бодлого” болон “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 400 орчим сая ам.доллар. Үүнд:

-Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төслийн хүрээнд 100.0 сая ам.доллар.

-“Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх засвар арчлалын төслийн III үе шат” санхүүжилтийн хүрээнд 150.0 сая ам.доллар.

-Эрдэнэбүрэн, Мянгад, Улиастайн эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөл.

-Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд хэрэгжүүлэхэд 50-иас 55 сая ам.доллар. Үүнд:

-“Хөдөө аж ахуйн Хөдөөгийн хөгжил төслийн II үе шат”.

Одоо хэрэгжиж байгаа төслүүдийн нэмэлт санхүүжилт хэлбэрээс 10-аас 15 сая ам.доллар. Үүнд:

-Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанарыг сайжруулах төсөл.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхийг зөвшөөрч өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Б.Баделхан гишүүн. Би дараа нь нэг асуулт асууя. Ингээд 3 гишүүн асуулт асууна. Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: 25 жилийн хугацаатай 2 хувийн хүүтэй энэ зээл авах ёстой зээл ээ. Зээлийг авахыг дэмжиж байна.

Авна гээд анх оруулж ирснээсээ хойш нэлээн хугацаа өнгөрчихлөө. Энэ хооронд энэ 7 төрлийн ажил хийж байгаа юманд өөрчлөлт орж байгаа юу?

Яг энэ 7 зүйл дээрээ тэр нөгөө **Research Development** гээд “судалгаа, хөгжүүлэлт”, **Research Council** гээд нөгөө “зөвлөл” гээд нэг юм байдаг шүү дээ. **Think Tank** гээд ч бид зөндөө л юм ярьцгаадаг.

Ер нь энэ аваад байгаа зээлийн ач холбогдлыг ер нь эрэмбэлдэг юм уу? Үүнийг яаж үзэж байна аа?

Бид чинь энэ бүтээн байгуулалтад нэг жоохон юм хийх болохоор гаднаас зээл авч л хийж байна л даа. Тийм. Хөгжил бүтээн байгуулалтдаа зээл аваад хийгээд байдаг.

Нийт зээлийн хэмжээ 33.4 тэрбум доллар. Үүнээс Засгийн газрынх нь 8.5 орчим байгаа байх. Дотоодын нийт бүтээгдэхүүний 50-н хэдэн хувь. 2024 онд 60 хувь болно гээд явж байгаа.

Тэгээд ер нь энэ зээлийн менежментийг ер нь юу гэж бодож байгаа вэ? Энэ чинь ирээдүйд бид үүрэг үйлдвэрлээд байгаа юм.

Энэ дотор байгаа 6 дугаар зүйлд байгаа төсөв, санхүү, эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэг гэж байгаа юм.

Яах вэ, төсвийн дэмжлэг энэ тэр гээд яах вэ нэгдсэн нэр л байх л даа.

Банкны салбарт бодлогын шинэчлэл хийх. Энэ банкны салбар чинь бүгд хувийн банк биз дээ? Төрийн банкнаас бусад нь.

Татварын удирдлагын нэгдсэн системийг шинэчлэх гэж байгаа юм. Үүнийг IT-гийн нэг компани хийнэ шүү дээ. 20 жилийн өмнө гаалийн автоматжуулсан системийг хэдэн залуучууд л хийчихсэн байхгүй юу.

Тэгээд энэ хэр зэрэг оноод байдаг юм бол доо.

Энэ дотор нэг гайгүй явж байгаа нь хөдөө аж ахуйн “**Хөдөөгийн хөгжил II үе шаг**” гээд энэ бизнес эрхлэгчдэд

зээл өгөх юм байна. Хүнсний хангамжтай холбоотой 55 сая доллар.

Энэ бол их эвтэйхэн харагдаж байна. Энэ буцаж төлөгдөнө.

Тэгээд энэ төсөв, санхүүтэй холбоотой энэ маань хэр зэрэг оновчтой байдаг юм бол доо. Би үүнийг яагаад хэлээд байгаа юм гэхээр Монгол Улсад хөгжлийн эрэмбэ, зээл авч хийх ажил асар их олон. Хэдэн зуугаараа байна л даа.

Монгол Улс нийт эрчим хүчнийхээ 18 хувийг импортоор авдаг. Жилд бараг 200-аад сая доллар гадагшаа төлчихдөг.

Тавантолгойн цахилгаан станцыг барих чиглэлд бодож байгаа юм байгаа юу? Мэдээж гадна дотнын зээлээр л хийх байх.

Стратегийн томоохон ордууд дээр энэ Асгат гээд л, Хармагтай гээд л ярьдаг шүү дээ. Энэ ордууд дээрээ ер нь ямар бодлого барьж байгаа вэ? Гаднаас мэдээж хөрөнгө босгох байх.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хараад байгаа юу? Оюу Толгой шиг ийм үр ашиггүй юмнууд хийгдэх үү, үгүй юу?

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг бид баталсан. Энэ Хөрөнгө оруулалтын банк дээрээ дүрмийн санг нь нэмээд томоохон үр ашигтай хөрөнгө оруулалтууд дээрээ хийх ажил байх уу, үгүй юу?

Эдийн засгийн өсөлтийг дэмждэг салбарууд дээрээ бага хүүтэй урт хугацаатай зээл хэрэгтэй байгаа юм.

Өнөөдөр манай бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацаатай зээл хэрэгтэй байгаа юм.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, төвлөрлийг бууруулах, орон нутагт бизнесийг дэмжих чиглэлд юу хийж болох вэ?

Мэдээж хөдөө аж ахуйд 55 сая доллароор хэмжигдэхгүй байх л даа. Хөдөө аж ахуй гэж.

Монгол Улсын хоёр дахь том гарц, уул уурхайн дараа хөдөө аж ахуй.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлд юу хийж болох вэ?

Монгол брэндийг дэмжих чиглэлд гадаадын зээл, тусламжийг авах.

Шинжлэх ухааны инновацад мөнгө зарцуулах гээд зөндөө л юм байна л даа. Тэгээд энэ хэр зэрэг эрэмбэлсэн юм бол оо?

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Болдын Жавхлан сайд хариулъя. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Б.Батгөмөр гишүүний асуултад хариулъя.

Өмнө нь хэд хэд танилцуулагдаж байсан. Тэр үед соёрхон батлах хөтөлбөр учраас жагсаалт, төсөвт өртөг, зүйлүүд тодорхойгүй байсан.

Энэ удаа оруулж ирж байгаа жагсаалт бол өмнө нь Байнгын хорооноос өгсөн чиглэл, жагсаалтын хүрээнд танилцуулагдаж байгаа гэдгийг хэлье.

Мэдээж төсвийн дэмжлэг болон бодлогын матриц нь санхүү, төсвийн чиглэлээр байдаг. Арга хэмжээнүүд нь хийгдээд явж байгаа. Энэ нь шууд төсөв дээр орж ирээд гадаад валютын нөөц дээр дэмжлэг болох ийм бодлогоор орж ирж байгаа гэсэн үг.

Эрэмбэлэхийн хувьд ерөөсөө Улсын Их Хурал дээрээс батлагдсан **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын хүрээнд тэр жагсаалтыг эрэмбийн дагуу орж ирж байгаа гэж ойлгож болно.

Тухайлан төслүүд асууж байна. Эрдэнэс Тавантолгойн дулааны цахилгаан станц. Жишээ нь, үүнийг “Эрдэнэс Тавантолгой” компани өөрийнхөө хүрээнд шийдээд явахаар өнөө маргаашгүй тендер нь зарлагдахаар бэлэн болсон байгаа.

Мөн Засгийн газар дээрээс зөвхөн дулааны цахилгаан станц төдийгүй манай Монгол Улсын өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчийг хангахад нэг биш шинэ эх үүсвэр үйлдвэрүүд шаардлагатай байгаа учраас энэ салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалтуудыг татварын бодлогоор дэмжих ийм зохицуулалттай хуулиуд мөн өнөөдөр өглөө тухайлбал Төсвийн байнгын хороогоороо ороод дэмжигдээд явж байгаа.

Хөрөнгө оруулалтын банкны хувьд хууль нь батлагдсан. Энэ нь төрөөс биш хувийн сектор гадаад шууд хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын чиглэлээр банк байгуулж ажиллахыг дэмжсэн. Энэ зах зээлийг либералчилж нээлттэй болгож байгаа ийм хууль.

Тийм учраас бид хөрөнгө оруулалтын орчин, бизнесийн орчин маань өөрөө тэлэх, өсөхийн хэрээр хөрөнгө оруулагч нар сонирхож орж ирэх байх гэж ийм хүлээлттэй ийм хууль байгаа юм.

Тийм учраас бид эрсдэлээ багасгах. Улсаас шалтгаалах зээлжих зэрэглэл ч гэдэг юм уу, эдгээр юмнуудыгаа л бид анхаарч ажиллах нь энэ хуулийн хэрэгжилтэд нэмэр болох зүйл гэж бодож байна. Тийм.

Н.Энхболд: Тодруулах уу?
Б.Баттөмөр гишүүн. Б.Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: 25 жилийн дараа бид байхгүй. Энд, Тэр бол баталгаатай.

Бид өр үйлдвэрлээд байгаа. Энэ өрөө үр ашигтай зүйлд зарцуулах юмсан.

Монгол Улс 30 жил ардчилал, зах зээлийн нийгмээр хөгжөөд өнөөдөр явахдаа асар их хэмжээний тийм хүндрэлтэй байдал үүсгэчихсэн байгаа.

Гаднын зээлийг үр ашигтай зүйлд зарцуулах юмсан гэдэг л санааг хэлж байгаа юм. Яах вэ, хөрөнгө оруулалтыг нь банканд оруулдаг байгаа юм. Хөгжлийн банкаа дэмжихгүй юм уу? Баахан үр ашиггүй юмнуудыг аваачаад санхүүжүүлчихсэн.

Би Хөгжлийн банк байх ёстой, хөгжлийг санхүүжүүлэх ёстой гэж ярьдаг. Үүндээ эх үүсвэр олгохгүй юм уу?

Хөгжилд энэ зүйлээ зарцуулъя. Зам тавиад, шугам татахаар энэ яах вэ нэг утгаараа хөгжил гэж харагдах боловч нөгөө талдаа эдийн засгийн өсөлтөд шууд утгаараа бий болгодоггүй. Энэ чиглэлд л юм яриад байгаа юм л даа.

Б.Энх-Амгалан: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Хөгжлийн банкны хувьд Монголын ард түмэнд нээлттэй байгаа.

Хөгжлийн банкний үйл ажиллагааг нь тэлж зээл өгөх битгий хэл одоо бид энэ жил үлдсэн гэрийн даалгавруудаа биелүүлэхээс нааш энэ банкныг бүрэн эдгэчихсэн, бүрэн хэвийн

үйл ажиллагаагаа явуулах хэмжээнд оччихсон гэж хэлэх болоогүй байгаа цаг.

Намар бид тус банктай холбоотой хоёр том бондын зохицуулалтыг хийх шаардлагатай байгаа.

Ямар ч байсан нэг бонд дээр санаа зовох зүйлгүй болсон.

9 сард “Евро бонд” буюу 400-аад сая доллар үлдлээ. Эдгээр бондуудыг цэгцлээд энэ оны эцсээр тус банкны баланс хэвийн байдалд орж, цаашдаа яг энэ хуулийнхаа хүрээнд хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх, яг банк утгаараа ажиллах боломж нь нээгдэх юм.

Тэгэхээр одоо нэг тийм завсрын үе нь байна л даа. Энэ банкныг авч үлдэх, цааш нь эдийн засагт нэмэртэй тэр банканд нь аваачих.

Яах вэ, бид ингээд л чанаргүй зээлүүдтэйгээ ноцолдоод арайхийж нэг жоохон төлөвлөж аваад ингээд хэвийн үйл ажиллагаанд орох болоод ирмэгц дараагийн асуудал гарч ирж байгаа юм.

Тэр нь юу вэ гэвэл цаашдаа энэ банк засаглалын хувьд яаж цаашаагаа оршин тогтнох вэ. Буцаад л нөгөө алдаагаа давтаад өмнөх байдлаар ингээд явуулах уу. Цоо шинэ ахисан түвшинд засаглалыг нь сайжруулж цааш нь явуулах уу гээд.

Энэ бол том дараагийн бодит сорилт болж гарч ирнэ. Цаг хугацааны хувьд. Өнөөдөр яригдахгүй байгаа ч гэсэн.

Тийм учраас эхний ээлжид би богинохондоо юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр эхлээд нэг хэвийн байдалд нь оруулаадахъя.

Дараа нь үнэхээр итгэлтэйгээр урагшаагаа харж явж чадахаар үед нэмэлт эх үүсвэр, хөнгөлөлттэй зээлүүд нь хаашаа ямар чиглэлээр явах юм, Засгийн газарт ямар нэмэр болох юм, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын ямар төслүүдийг санхүүжүүлж чадах юм гээд. Энэ бол дараагийн даалгаврууд болно байх гэж бодож байна. Тийм.

Б.Энх-Амгалан: Х.Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд энэ төслүүдийг хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа.

Хилийн боомтуудыг тохижуулах юм байна. Тэгээд зарим нэг зам харилцааг сайжруулах юм байна. Өмнө нь бид бас ярьж байсан.

Тийм учраас энэ төслийг дэмжиж байгаа.

Бид бас нэг төсөл. Энэ Азийн хөгжлийн банктэй хамтраад “**Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр**” гэж бас 1 дүгээр сард сард ярьж байсан шүү дээ.

Энэ асуудал өнөөдөр орох юм уу? Өнөөдөр орохгүй. Тийм ээ.

Энэ ямар шатандаа байгаа юм бэ? Би үүнийг л асуучихмаар байна.

Б.Энх-Амгалан: Манай Байнгын хорооны өргөн бариагүй байгаа шүү. Орж ирээгүй байгаа.

Х.Баделхан: 1 дүгээр сард ярьсан. Одоо ямар шатанд байна. Хэзээ өргөн барих вэ? Чуулганыг хэзээ оруулах вэ гэдгийг л асуумаар байна л даа.

Б.Энх-Амгалан: Б.Жавхлан сайд. 2 номерын микрофон хариулах уу? 2 номерын микрофон хариулъя. Нэрээ хэлээд хариулаарай.

Б.Одонтуяа: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өргөн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа. Гишүүний асуултад хариулъя.

“**Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр**”-ийг өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хурлаар хэлэлцээд өргөн барихаар бэлтгэл ажлыг хангасан байгаа.

Тэгэхээр ойрын хугацаанд өргөн баригдана гэсэн үг. Тэгээд Аюулгүй байдлын байнгын хороогоор хэлэлцээд Их Хурлын чуулганаар нэг удаа бас хэлэлцэнэ.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Д.Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Тогтоолын төслийг дэмжиж байгаа.

Нэг зүйл асуумаар байна. Азийн хөгжлийн банктэй бид үнэхээр олон жил түншилж, олон жил зээл, тусламж авч ажиллаж байгаа.

Тэгээд ер нь урьд өмнө авсан зээлүүд маань үр өгөөж нь ямар байгаа вэ? Өөрөөр хэлбэл эргээд бид төлөх ёстой учраас. Жишээлбэл, тодорхой төсөл дээр, эсвэл бүхэлд нь багц дээр нь Та нар ийм судалгаа хийж үзсэн үү?

Одоо тэр төслүүд хэрэгжээд бид эргээд төлөхөд чинь Монголын эдийн засагт ямар нэмүү өртөг бий болсон бэ?

Өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн бааз нэмэгдсэн үү? Татварын орлого үүнтэй холбогдоод хэр нэмэгдсэн бэ?

Яагаад гэвэл эргээд тэндээсээ л төлөх учраас. Энэ маань хэр хуримтлагдаж, хэр эргэн төлөгдөж явж байгаа вэ?

Тэгэх юм бол ийм зээлүүд авахад аюулгүй. Яагаад гэвэл эргээд энэ чинь буцаад төлөгдөх орлогоо төрд бий болгож өгөөд нэмэгдүүлээд байгаа бол ийм зээлийг аваад хөгжилдөө ашиглаад явах нь маш зөв.

Тэгэхээр тэр тооцоогоо бид хийсэн үү? Жишээлбэл, ахиад нэг хэмжигдэхүүн юу вэ гэхээр Азийн хөгжлийн банкны энэ том төслүүд хэрэгжсэнээр Монголд хэдэн ажлын байр шинээр бий болсон бэ? Ийм тооцоонууд бид гаргасан байгаа юу? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт. Б.Жавхлан сайдаас нэг зүйл асуумаар байна.

Манай Сүхбаатар дүүргийн 13, 15 дугаар хороон дээр байх. Нөгөө дэд станцууд баригдаж байгаа. Азийн хөгжлийн банкны. Тэгээд дэд бүтцүүд хийгдээд явж байгаа юм.

Сая иргэдтэй уулзаад явж байхад энэ ажил зогсчихсон байгаа. Уг нь энэ чинь одоо Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй явж байгаа төсөл зогсох ёсгүй шүү дээ. Дэд станцууд баригдаж байгаа юм.

Тэнд ер нь дэд бүтэц хийгдээд нөгөө халуун, хүйтэн усны шугамууд баригдаад айлууд руу тэр дулаан өгөх дэд бүтэц баригдаад явж байгаа. Тэгтэл одоо энэ ажлууд нь нэлээн хэдэн жил амжилттай хийгдээд явж байснаа зогсчихсон байна лээ. Нэг асуулт.

Хоёр дахь асуулт. Яах вэ, мэдээж зөрчилтэй. Гэхдээ бид үүнийг зах зээл өөрөө шийднэ гээд хаяж болохгүй л юм билээ.

Тэр дэд бүтцийн шугам сүлжээ, инженерийн шугам сүлжээг айлууд руу ингээд аваачихаад. Айлууд бол ингэж байгаа юм. Бид гэр лүүгээ оруулахад бидэнд ямар дэмжлэг, хөнгөлөлттэй зээл юу байна. Түүнээс Та нар ингээд өөрсдөө шийдэх ёстой. Дэргэд чинь аваад ирлээ шүү дээ гээд хаях юм бол тэр иргэд маань өөрсдөө тэгж хийж чадахааргүй юм билээ.

Тэгэхээр мэдээж үнэгүй оруулж өгнө гэдэг бол хэцүү байх. Тэгвэл зах зээлийн өөр ямар механизм байна вэ? Үүнийг яаж хэрэгжүүлэх вэ гэдгээ бид бас бодохгүй бол зөнд нь орхиод нэг их том хөрөнгө оруулалт хийгээд эргээд яг иргэдэд зориулж уг нь хийж байгаа юм чинь тэр иргэд нь ашиглах нөхцөл нь нэг жоохон юм хүрэлгүй ингээд үлдчихдэг. Тэгээд тэрийгээ бид хийлгүй үлдээгээд яваад байж болохгүй юм билээ.

Тэгэхээр өөрсдөө бас санаачилж ямар нэгэн шинэ механизм, санхүүжилтийн тэр боломжийг нээж өгөх тал дээр тархиа ажиллуулах л ёстой юм билээ. Ингээд ийм гурван асуулт байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Болдын Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Эхний асуулт Д.Цогтбаатар гишүүний.

Ер нь ийм юм байгаа юм. Бид 1990 оноос хойш цоо шинэ зээлийн харилцаанд орсон. Өмнө нь ганц эх үүсвэртэй л байлаа шүү дээ.

Ингээд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк гээд олон талт хөгжлийн институттэй ийм зээлийн харилцаанд орж өнөөдрийг хүртэл нийтдээ 7.7 тэрбум долларын урт хугацааны. Анх бид чинь нэг хөнгөлөлттэй авдаг байсан. Одоо

чинь жоохон бид чинь сайжраад нөгөө хөнгөлөлттэй рүүгээ орчихсон. Арай жоохон хатуурчихсан ингээд явж байгаа.

Одоо 5.1 тэрбум доллар орчим үлдэгдэлтэй. Үүний 2.3 тэрбум нь Азийн хөгжлийн банкны үлдэгдэл байгаа. Бусад нь бусад институц. Хоёр талтууддаа хийгээд явна.

Тэгэхээр өнөөдрийг хүртэл манай хамгийн том зээлдэгч, хамгийн том санхүүжүүлэгч бидэнтэй хамгийн ойрхон ажилласан гэх юм уу, институц маань энэ байгаа юм. Азийн хөгжлийн банк.

Өнөөдрийг хүртэл 33 жилийн түүхэнд эдгээр зээлүүдийг бид юунд авч ашиглав гээд ерөнхий зургаар нь харах юм бол 66 хувь нь Монгол Улсад биет байдлаар хөрөнгө оруулалт болж байшин барилга, тоног төхөөрөмж болж үлдсэн. 34 хувь нь илүү их нийгмийн чиглэл рүүгээ гэсэн үг. Нийгмийн чиглэл рүүгээ. Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр ингээд явчихсан гэсэн үг.

Тэгэхээр цаашдаа бид дараагийн 3 жилийнхээ гадаад өрийнхөө удирдлагын стратегийг Их Хурлаар батлуулаад авчихсан байгаа. Өнгөрсөн жил. Гурав гурван жилээр явдаг.

Тэнд юу явж байгаа вэ гэхээр илүү их эдийн засгийн үр өгөөж дээр суурилсан. Өөрөөр хэлбэл өмнө нь бид бас нийгмийн чиглэл рүүгээ нэлээн явуулчихсан байна.

Тэгвэл одоо дараагийн 10, 20 жилд бид үүнийгээ шилжилт хийх ёстой. Яг таны хэлж байгаа зээл болон эдийн засгийн үр өгөөжтэй. Нийгмийн гэхээсээ илүү эдийн засгийн өгөөжтэй, зээл болгон ажлын байр нэмэгдүүлдэг, зээл болгон төлбөрийн тэнцэл дээр эерэг үр

дагавар авчирдаг ийм зээл рүү шилжиж байгаа.

Тийм учраас нөгөө богино хугацааны ийм бондын эх үүсвэр, бондын зээлийг Засгийн газар орохгүй, одоо. Зөвхөн урт хугацааны хөгжлийн зээлүүд дээрээ авч үүнийгээ яг эдийн засгийн чиглэлийн, **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ынхоо чиглэлийн төслүүд рүү түлхүү оруулна гэдгийгээ Их Хурлаараа батлуулж аваад Засгийн газрын гэрийн даалгавар аваад ингээд ажиллаж байгаа гэсэн үг.

Ийм чиглэлээр бид бодлогын шилжилт хийж байгаа гэдгийгээ хэлье. Сүхбаатар дүүргийн дэд бүтцүүд дээр хэн хариулах юм. Ж.Ганбат аа? Ж.Ганбат

Б.Энх-Амгалан: Б.Жавхлан сайд хариулаад дуусчихсан уу? Нэмж 1 номерын микрофоныг өгье. 1 номерын микрофон хариулья.

Б.Ганзориг: Энэ Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй...

Б.Энх-Амгалан: Нэрээ хэлээрэй.

Б.Ганзориг: Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг. Д.Цогтбаатар гишүүний асуултад хариулья.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжээд явж байгаа энэ Дамбадаржаа болон Сэлбэ дээрх дэд төвүүдийн ажил байгаа. Энэ дэд төвүүд дээр ер нь төрийн үйлчилгээнд нэгдсэн төвүүд, мөн инженерийн шугам сүлжээний ажлууд хийгдэх ёстой байгаа.

Тэгээд энэ дээр газар чөлөөлөлтийн асуудал нийслэлийн төсөв дээр суугаад явж байсан сайн асуудлууд нийслэлийн төсвөөс нь шийдэгдээгүй асуудлууд байгаа.

Тэгэхээр газар чөлөөлөлттэй холбоотойгоор төслийн хэрэгжилттэй холбоотой ажил жоохон удааширч байгаа ажлууд байгаа.

Ер нь бид хоёрын тооцоогоор 24 сар орчмоор яг хэрэгжилтийнхээ явцаас хоцроод явж байгаа. Тэгэхдээ бид Азийн хөгжлийн банктай тохироод Азийн хөгжлийн банкныхаа зээлийн хөрөнгөөс нийслэлээс санхүүжих ёстой байсан тэр газар чөлөөлөлтийн төлбөрүүдийг шийдээд газар чөлөөлөлтийн төлбөрүүд нь эхнээсээ Сангийн яаман дээр орж ирээд газрын төлбөрүүд нь хийгдээд явж байгаа.

Тэгэхээр ажил цаашдаа үргэлжлээд явна гэсэн үг.

Б.Энх-Амгалан: Гурав дахь асуултад нь хариулъя. Хэн гүйцээж хариулах вэ? Гуравдугаар асуудал нь Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Төслийн хүрээнд тэгж өрхүүд рүү орох тийм ажил байхгүй. Өөрөөр хэлбэл энэ улсын хөрөнгө оруулалтаар зээл чинь нэг талаар бас л улсын хөрөнгө оруулалт шүү дээ. Урт хугацаандаа бид татвар төлөгчдийн мөнгөөр л төлөх юм байгаа юм.

Тэрийг хувь айл өрхийн хэрэгцээнд зориулж юм уу, өөр хувийн байгууллагын баланс дээр бичигдэх хөрөнгө оруулалтын хэмжээнд бид зарцуулж ерөөсөө огт болохгүй.

Ер нь хэд хэдэн аймгууд дээр төслүүд нь яг айл руу, яг хашаа руу нь орох ийм юман дээрээ очоод л бас шийдэлгүй хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалтуудыг эцсийн үзүүр дээрээ очоод үр өгөөжгүй болж ирж байгаа, сарних бас ийм эрсдэлүүд байгаа. Ганцхан Сүхбаатар дүүрэг дээр ч биш.

Тэр бол моргейж арай л биш юм. Зүгээр тэр дээр цэвэр яг өөрийнх нь арилжааны шугамаар л айлуудад нь шийдлийг нь үлдээгээд. Түүнд нь Зээлийн батлан даалтын сан ч байдаг юм уу, тийм л байдлаар оролцоно уу гэхээс. Түүнээс биш нэг татвар төлөгчдийн мөнгөөр нэг иргэний хувийнх нь асуудлыг нь шийдэж гэр лүү нь тэр дэд бүтцийг нь татаж өгдөг зүйл байж болохгүй байх. Тийм.

Б.Энх-Амгалан: Д.Цогтбаатар гишүүн тодруулъя. 1 минут.

Д.Цогтбаатар: Яг би үүнийг ярьж байгаа байхгүй юу. Мэдээжийн хэрэг би айл руу оруулж өг гэж тийм санал тавиа ч үгүй, тийм юм асуусан ч үгүй шүү дээ.

Тэгэхдээ үүнийг зүгээр ингээд үлдээчих юм бол сайд аа, юу болж байна гэхээр. Одоо өөр газар бас байгаа юм байна шүү дээ. Хэчнээн их хөрөнгөөр дэд бүтцийг нь тавьж өгчхөөд энэ дээр нь бид толгойгоо ажиллуулж шийдэл гаргаж өгөхгүйгээр үлдээчих юм бол тэр хөрөнгө чинь ашиглалтгүй болчхож байгаа. Бүр хоёрын хооронд юм болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр дээр нь санхүүгийнх нь механизмыг бид өөрсдөө бодож өгч шийдэхгүй бол одоо мэдээж моргейж биш байлаа гэхэд тэр Та сая Батлан даалтын сан гэж байна шүү дээ. Эсхүл тэр газрын үнэлгээн дээр нь сууриалаад банкнуудад ямар нэгэн зээл олгох боломж, тэр батлан даалтын сангаар дамжуулаад хийх үү?

Ингээд нэг ийм юм бид бодож олж механизмыг нь хөдөлгөх тэр нэг жоохон даваан дээр очоод гацчихаад байгааг нь хөдөлгөж өгөх механизмийн л бас бодох хэрэгтэй байгаа юм байна лээ дээ.

Тэгэхгүй бол явахгүй юм байна лээ. Яг бодит амьдрал дээрээ.

Б.Энх-Амгалан: Би хэдэн асуулт асууя.

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл анх бас л намайг Зам, тээврийн сайд байхад л яригдаж байсан ийм төсөөлөлтэй эхлүүлж байсан.

Тэгээд энэ гуравдугаар үе шат явж байна. Төслийн хүрээнд хийгдэх үндсэн ажлууд дотор гүүрүүдийн их засварын шинэчлэлтийн ажил байгаа юм.

Тэгээд энд 2020 оноос эхлээд л яригдсан нэг ажил бол Завхан, Говь-Алтайн. Төрийн нарийн мэдэж байгаа байх. Завхан гол дээгүүр тавих Бүрэнгийн гүүрний асуудал.

Энэ Бүрэнгийн гүүрний асуудлын зураг төслийг ярьсаар байгаад өдий хүрсэн. Тэгээд зураг төсөл нь дууссан.

Энэ Говь-Алтайн 4 сум. Хөх морьт, Баян-Уул, Жаргалант, Тайшир. Завханы 3 сум. Цагаанхайрхан, Цагаанчулуут, Алдархаан сумын энэ малчин иргэд чинь голынхоо хойд талд гарчихаар, элсэх рүүгээ гарчихаар эргээд зун наашаа нүүх гэхээр Завханы төв ороод тэгээд Ганцын даваа даваад бараг 100 гаруй километр тойрч байгаа юм. Шууд ингээд голынхоо урд наана гарахад ийм бололцоотой энэ төслийг хэрэгжүүлж өгөөч ээ гэж нэлээн хүссэн. Энэ энд орсон уу? Үүнийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт нь, Говь-Алтайн, Улиастай чиглэлийн зам чинь яг хаанаасаа эхлэх гэж байна. Энэ дээр ингээд харахаар зэрэг Цагаанхайрхан, Цагаанчулуут чиглэлийн 60 километр, Наранбулаг, Улаангом чиглэлийн 163

километр гээд ингээд. Улиастай, Цагаанхайрхан чиглэлийн 40 километр гээд. Энэ зам чинь Говь-Алтайгаас эхлэхгүй юм биш үү? Энэ яасан юм? Уг нь ач холбогдлын хувьд Та нар мэдэж байх ёстой. Энэ чинь Арцсуурь, Бургастайг холбосон босоо тэнхлэгийн хамгийн ойрын зам шүү дээ.

Үүнийг чинь тэгээд нөгөө хэлэлцээрт орж байхдаа энэ хоёр талыг нь хоёуланг нь явуулья гээд байсан. Наранбулаг руу одоо жишээлбэл яг ямар асуудлаар ингээд ийм өндөр тоо тавьчихсан юм. Энэ явах юм уу, явахгүй юм уу?

Гуравдугаарт нь, намын мөрийн хөтөлбөрт орсон орон нутгийн чанартай **“Нутгийн зам”** төслийн хүрээнд Говь-Алтайд 5 сум холбоё гээд. Дарви, Шарга, Дэлгэр, Баян-Уул, Хөхморьт гээд хэдэн сумд байсан. Түүнээс **Дэлгэр сум 8 километр, Шарга сум 17 километр, Баян-Уул сум 20 километр** гээд ийм ойрхон ойрхон, төв замтайгаа ойрхон байдаг 3 сумыг энэ **“Нутгийн зам”**-ын төсөл дээр холбоё гээд 2020 оноос хойш л жил болгон л санал өгөх юм. Тэгээд энэ орсон уу, ороогүй юу?

Ямар аймгууд нь бүх сумаа холбочихдог, ямар аймагт нь нэг ч сум холбогддоггүй юм бэ? Үүнийг би тодруулах гээд байгаа юм. Үүнийг тодруулж өгөөч. Ямар шалтгаанаар эд нар хасагдчихав?

Говь-Алтай аймгийн нэг ч сум аймгийнхаа төвтэй эсвэл төв замтайгаа засмал замаар холбогдоогүй.

Тэгээд хамгийн ойрхон 8-хан километр зам холбож чадахгүй байгаа юм уу? Энэ яагаад болохгүй байгаа юм?

Дөрөв дэх асуудал. Энэ **“Боомтын сэргэлт”**-ийн хүрээнд энэ бүх

боомтуудаа оруулаад л боомтын сэргэлт, боомтын хөгжлийг тэгээд л хангах төлөвлөгөө гээд явж байна.

Энд Бургастайн боомт яагаад ороогүй юм. Бургастайн боомтоор чинь Алтайн хүдрийн гол төмрийн хүдэр гарч байгаа шүү дээ. Эд нар чинь өөрсдөө цааш нь зам тавьчихсан шүү дээ. 80 километрээр замаа хуччихсан. Одоо үлдсэн замаа хучих ийм ажлууд эхэлж байгаа.

Тэгээд энэ экспортын чиглэлийн гол төмрийн хүдэр, тэгээд Хөхцав болоод тэр Мааньтын нүүрсийг чинь гарах гол зам нь энэ шүү дээ. Тэгээд үүнийгээ холбохгүй юм уу? Энэ боомтыг оорхичхож байгаа юм уу? Эсвэл Хятадын талаас энэ боомтыг хөгжүүлэхгүй гэсэн юм уу?

Ийм дөрвөн асуултад маш тодорхой хариулт өгөөдөхөөч. Хэн хариулах вэ? Б.Жавхлан сайд эхлээд хариулья.

Б.Жавхлан: Замынүүдийг л дурдах юм байна. Тийм.

Б.Энх-Амгалан: 5 номер. Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд хариулья.

С.Батболд: Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Б.Энхамгалан гишүүний асуултад хариулья.

Өнөөдрийн орж ирж байгаа энэ замын маршрутын дагуу Бүрэнгийн гүүр арай ороогүй байгаа. Маршрут нь арай өөр чиглэлээр явж байгаа учраас энэ төсөлд Бүрэнгийн гүүр ороогүй байгаа.

Хоёр дахь асуудал нь, Говь-Алтай, Улиастайн энэ зам хаанаасаа эхлэх вэ гэж.

Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Азийн хөгжлийн банк гурвын ажлын хэсэг хуралдаад 163 километрээр замын зураг нь 2013 онд хийгдчихсэн. Энэ нь Улиастайгаасаа урагшаа явж байсан ийм зураг байгаа юм билээ. Тэгээд 138 километр нь энэ зургаараа Улиастайгаас эхэлж байгаа гэдгээрээ энэ хэлэлцээрт Улиастайгаас Цагаанчулуут хүртэл байсан байх аа. 100 километр л гэж орж байгаа. Нийтдээ энэ хооронд 198 байгаа. Тэгээд энэ нөгөө санхүүжилтийнхээ хэмжээнээс болоод бүрэн орж чадахааргүй ингээд 100 километрээр орсон байгаа. Тийм.

Мөн гурав дахь асуудал нь нутгийн замын хүрээнд энэ 5 сум энд бас ороогүй. Яагаад ороогүй вэ гэхээр энэ зөвхөн гол замаа л явъя. Мөнгө нь хүрэхгүй байгаа учраас Монгол Улсын Засгийн газар өөрсдөө гол замаасаа энэ сумууд руугаа татах замаа өөрсдөө хариуцсан нь дээр гээд энэ төсөлд ороогүй байгаа юм. Тийм.

Б.Энх-Амгалан: Зам, тээврийн сайд С.Бямбацогт хариулья.

С.Бямбацогт: Тийм. Манай С.Батболд дарга уг нь олон жил яамны Төрийн нарийн бичгийн дарга хийж байгаа. Урьд нь бас Зам, тээврийн хөгжлийн сайд байсан энэ сайдынхаа урьд нь ярьж байсан асуудал, одоо ярьж байгаа асуудалд анхаарах ёстой л доо. Таны хариулт хангалтгүй байна.

Болохгүй, бүтэхгүй гэсэн л юм хариулж байна. Харамсалтай байна. Тийм. Аль болох болгох бүтээх талаас нь Та бас бодоод хариултаа өгсөн бол уг нь баярлах байлаа.

“Нутгийн зам” хөтөлбөрийн хүрээнд бид нэлээн олон сумдыг хатуу

хучилттай замаар холбох бодлого уг нь барьж байгаа. Аль болох.

Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн яамнаас 136 төслийг хийж хэрэгжүүлбэ. Энд олон сумууд. Таны ярьж байгаа Говь-Алтайн нэлээн хэдэн сумдыг холбох саналуудыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Харамсалтай нь Эдийн засгийн хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн 136 төслөөс 34 төслийг л ирэх жил бид санхүүжүүлж хэрэгжүүлэх бололцоотой гэдэг байдлаар хасагдсан байгаа. Уг нь бид оролдоод л байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, тэр Бургастай боомттой холбоотой асуудал дээр **“Боомтын сэргэлт”**-ийн бодлогын хүрээнд ерөөсөө боомт руу чиглэсэн замуудыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон гаднын зээл, тусламжаар ерөөсөө нэг ч зам барихгүй байгаа. Энэ замуудыг дандаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулж байгаа.

Энэ хүрээнд юу гэдэг юм Бургастайн боомтыг хилтэй холбох энэ замыг барья гээд саналаа оруулаад ирэх юм бол бид бүрэн дүүрэн дэмжээд бариулна.

Ховдын Үенчээс, Булганаас Байтагийн боомтын чиглэлд зам барья гээд санал ирсэн. Бид дэмжиж байгаа. Сүхбаатарын Бичигт чиглэлд дэмжиж байгаа. Гэх мэтчилэн одоо юу гэдэг юм боомт чиглэсэн замуудыг улсын төсвийн хөрөнгөөр биш хувийн хэвшлийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэлээр бариад ашиглах энэ бодлогыг дэмжинэ. Тийм болохоор ийм саналаа тавиад ирэх юм бол үүнийг дэмжээд явах бас бололцоотой.

Дараагийн асуудал. Ер нь Монгол Улс чинь Орос, Хятад хоёр улстай Алтанбулаг, Замын-Үүд чиглэлээрээ нэг хатуу хучилттай замаар холбогдсон. Нөгөөдөх нь Баян-Өлгийн Цагааннуур, Ховд, Ярантын чиглэлтэй холбогдсон байгаа юм.

Увсын Улаангом, Ховдыг холбох юм бол дахиад Оросын Холбооны Улсын Тувагийн Бүгд Найрамдах Улс, дахиад Увсаар дамжаад Ховдоор ингээд үндсэндээ бас дахиад нэг босоо тэнхлэгээрээ эдийн засгийн гурав дахь эдийн засгийн авто замын коридор бий болох ийм бололцоо бүрдэх үүднээсээ гэж үзэж Азийн хөгжлийн банк, Сангийн яам ярьж байгаад л ийм замын чиглэлийг тохирсон юм шиг байгаа юм.

Тэгэхээр Улиастай, Говь-Алтай чиглэлийн энэ дээр дутагдаж байгаа хөрөнгийг Азийн хөгжлийн банкны 4 дэх ээлжийн төслөөс санхүүжүүлэхээр төлөвлөөд санхүүжилтийн эх үүсвэрийг бас урьдчилсан байдлаар ярилцаад явж байгаа.

Тэр замын эхлэлийг би бас эргэж ярьж болно гэж үзэж байгаа. Заавал Завханаасаа Улиастайгаасаа биш Алтай чиглэлээсээ эхлэх бололцоотой гэж үзэж байгаа.

Б.Энх-Амгалан: Нээрээ гомдмоор юм аа. Тийм ээ. Зам, тээврийн яамныхан шүү дээ. Та нар.

Тэгээд би 2020 оноос хойш бараг л жил болгон энэ асуудлыг тавьж байгаа. Бүрэнгийн гүүр 8 сумын иргэдтэй холбоотой асуудал шүү. 100 километр тойрдог шүү. 10 километр хүрэхгүй ингээд гол гарчих ганц гүүр тавиад өгөөч гэж хүсээд тавигдаагүй ээ гэдэг хариу аваад сууж байгаа юм.

Шалтгаан нь яагаад. Яах вэ улсын төсвийн хөрөнгөөр тавигдах юм. Тэгээд улсын төсвийн хөрөнгө дээр яагаад Зам, тээврийн яам оруулж ирдэггүй юм бэ? Оруулаад өгөхөөр яагаад Сангийн яаман дээр аваачиж тавьдаггүй юм бэ? Энэ чинь 8 жил болчхож байгаа зам шүү дээ. Явахгүй. Тэр гүүр.

Хоёр дахь нь. Нэг юм ярьж байгаа юм. Аялал жуулчлалыг хөгжүүлэх энэ маршрутын хүрээнд гэж. Хөөш тэр Тайшир чинь “А” бүс шүү дээ. Монголд байдаг ганцхан усан цахилгаан станц тэр Гэгээн нуур луу чинь очдог зам нь Тайшир байхгүй юу.

Тэр рашааны гол эх үүсвэр чинь тэр Хүнхэр байхгүй юу.

Тэгээд яагаад Говь-Алтайн түүгээр тавихгүйгээр Цагаанчулуутаар явж байгаа юм? Тэгээд сайд чинь эхлэлийг нь хаанаас ч явуулж болно л гэж байна шүү дээ.

Яадаг юм энд Та нартай би өс хонзонтой болчихсон юм уу, яачихсан юм. Тэр Бургастайн боомт дээр чинь би зам тавиад өг гэж хэлээгүй шүү дээ. Алтайнхүдэр чинь замаа тавиад явж байгаа. Боомтыг нь хөгжүүлээд өгөөч гээд байгаа шүү дээ.

Хятад талдаа хөгжчихөөд манай талд наана чинь нэг ширхэг байшин ч алга байна шүү дээ.

Тэгээд “Нутгийн зам”-ын хүрээнд Та нар 8-хан километр 10-хан километр зам тавиад өгчхөөч. Нэг сум холбоод өгөөч гээд байхад өчнөөн газар л холбосон шүү дээ. Одоо ямар тэрийг би яриад суугаад байлтай нь биш. Яасан өөдгүй юм бэ Та нар чинь.

Б.Жавхлан сайдаас хариу хүсье. Эндээс ер нь биелэх юм байна уу? Биелэхгүй юу? Эсвэл.

Нээрээ онцгүй байна шүү.

Б.Жавхлан: Эдийн засаг хөгжлийн яамнаас өргөн барьж батлуулчихсан байгаа байх аа. Төлөвлөгөө батлагдсан байгаа юу? Тийм ээ. 2024 оных.

Одоо 2024 оны төсөв баригдах үед бид Их Хурал дээрээс батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө л барина даа.

Тэндээс зам дээр тавигдах хөрөнгө оруулалтуудын хэмжээ нь ямар байна тэндээс засаг дотор мэдээж чиглэлийн яам эрэмбэлж гаргаж ирнэ.

Тэгээд л яаж эрэмбэлэгдэх нь вэ тэндээсээ л эхнээс нь жигд хөрөнгө оруулалтуудыг нь тавиад төсөв даах хэмжээгээрээ ингээд л явна даа.

Юуны тулд бид Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай болсон билээ. Одоо бид хоёр дахь, гурав дахь жил рүүгээ орох гэж байна.

Тийм учраас энэ хуулийн хэрэгжилт, энэ концепцоо аль болох гажуудуулахгүй үүнийгээ хэрэглээд явах нь л чухал юм байгаа юм. Тийм.

Б.Энх-Амгалан: Би юу гэж ойлгох вэ? Говь-Алтайн Бургастын боомт дээр юу ч тавигдахгүй гэж ойлгох уу?

Тэгээд Дэлгэрийн 8 километр, Баян-Уулын арван хэдэн километр зам тавигдах боломжгүй ээ. Ер нь Говь-Алтайд юм тавихгүй ээ гэж ойлгох уу?

Бүрэнгийн гүүрний тэр зураг хийгдчихсэн. Ядаж эхлэл нь явахгүй юм уу энэ чинь. С.Бямбацогт сайд нэг

хариулаад өгөөч. Би энэ дээр бас протоколд үлдээх гээд байна.

С.Бямбацогт: Баларсан юм аа. Тийм.

Уг нь бид Эдийн засаг, хөгжлийн яам руу саналуудаа явуулсан. Түрүүн би хэллээ. Тийм ээ. 136 төслийн санал явуулсан нь дөнгөж 34 нь ороод 102 нь хасагдсан.

Тэгээд л тэр дотор л таны саяын ярьж байгаа юмнууд хасагдчихаад байгаа юм л даа.

Тэгэхээр гарцаа байхгүй бас тэр 8 километр зам. Дээрээс нь гарцаа байхгүй эдийн засгийн хувьд ачаа тээврийн эргэлтийн хувьд гэдэг юм уу, ач холбогдолтой тэр гүүрүүдийн асуудал дээр бас анхааръя.

Бидэнд бас тийм ээ, дараад нь төсөв хэлэлцэх үед тодорхой ярих орон зай гарах болов уу. Төсвийн санал дээр бид Сангийн яам руу 2024 төсвийн санал өгөхдөө онцгойлж анхааръя. Таны хэлж байгаа саналууд дээр. Манай яамныхан бас анхааралдаа авчхаарай. Бид бас анхаарах ёстой.

Уг нь чадлаараа л оруулах гэж оролдож байгаа. Харамсалтай нь одоо тэгээд л Эдийн засаг, хөгжлийн яам дээр очоод л нөгөө төслүүд хасагдахаар тэнд хасагдчихаад байгаа юм. Үүнийг Та бас зөв ойлгоорой. Ер нь боломжоороо.

Бургастайн боомтын хувьд боомтыг хөгжүүлэх томоохон бодлого явж байгаа. Боомтуудыг. Энэ хүрээндээ экспортын чиглэлтэй боомтууд дээр томоохон бодлогууд хэрэгжиж боомтын асуудал эрхэлсэн сайдын хүрээнд тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжихээр явж байгаа. Энд хамрагдаад явчих

бололцоотой болж байгаа болно гэж бид үзэж байна.

Б.Энх-Амгалан: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Уг хэлэх гишүүн байна уу? Б.Баттөмөр гишүүн үг хэлье. Б.Дэлгэрсайхан гишүүн үг хэлье. Н.Наранбаатар гишүүнээр. С.Бямбацогт гишүүнээр тасалъя. Б.Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Энэ зээлийн асуудлыг ойлгож байна. Тэгээд дэмжиж байна. Тэгээд би яг Б.Баттөмөр гишүүний хэлсэнтэй санал нэг байна.

Ер нь зээл аваад тэгээд улс бүтээн байгуулалт хийж байна гээд тэгээд ийм болоод л ингээд л өнгөрдөг. Тэгээд ер нь нэмэгдээд байдаг.

Зүгээр зээл аваад энэ Хөгжлийн банк болгочихолгүй шиг ийм хямд хүүтэй зээл байвал уг нь хувийн хэвшлийнхэндээ өгөөд жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, ер нь хүмүүсээ ажилтай, орлоготой болгох тал дээр ялангуяа ингэж ажиллахгүй бол зээл аваад л байдаг тэгээд төр өөрөө үүнийгээ өөрөө захиран зарцуулаад ингээд буцаад ер үүсээд байх нь үнэндээ харамсалтай байна.

Тэр зам бол маргаашийн асуудал шүү дээ. Яг үнэндээ бол. Өнөөдрийн асуудлаа л яримаар байгаа юм. Олон хүн ажил төрөлгүй байна, орлогогүй байна, иргэд их бухимдалтай байна.

Тийм учраас аль болохоор иргэддээ хүү багатай зээл өгөөд ажилтай, орлоготой болгох тал дээр нь бид уг нь өнөөдөр яримаар байгаа юм. Ялангуяа энэ Азийн хөгжлийн банкны энэ олон жил Монголын стратегийн түнш болж ирсэн ийм газраас бид ийм хямд өртөгтэй

зээл авч байгаа юм чинь иргэддээ хямд өртөгтэй өгвөл буцааж төлөгдөх нөхцөл нь бас боломжийн.

Тэгэхгүй Хөгжлийн банкнаас банкиг харж байхад үнэндээ авсан компаниуд нь бараг л хүүдээ идэгдээд таарсан юм байна гэж хараад байгаа юм.

Хэдий хүмүүсийг өнөөдөр буруутгаад яллаад байгаа боловч яг авсан том бүтээн байгуулалт хийсэн компаниуд нь өрөндөө, ялангуяа валютын алдагдлын зөрүүн дээр л дампуурах ийм байдал руу орчихоод байгаа нь хөндлөнгөөс харагдаж байгаа юм.

Тэгэхээр зэрэг ийм хүү багатай зээлийг л ард иргэддээ бүр хүртээмжтэй ийм байдлаар л өгч байж юм жоохон явуулмаар байгаа юм гэж хэлмээр байна. Тэгээд манай Сангийн яамныхан энэ дээр бас онцгой анхаарна биз дээ.

Одоо тэгээд нэгэнт авч байгаа юм ч их ч авсан адил, бага ч авсан адил. Ядаж талыг нь Хөгжлийн банкаа мөд босгохгүй гэж байх шиг байна. Тэгвэл ядаж Төрийн банкаараа дамжуулаад хүү багатай энэ боломж бололцоо, зээлийг өгч байж л энэ улс орон чинь явна шүү дээ.

Тэгэхгүй ингээд хэдхэн уурхайгаас цуглуулсан хэдэн төгрөгөө тэгээд буцаад зарчхаад тэгээд бүтээсэн ч юм байхгүй, иргэд нь тэгээд орлогогүй, ажилгүй л байна.

Тийм учраас би илүү энэ тэнд зам тавих том бүтээн байгуулалтыг ойлгож байна. Тэгэхдээ үүнийгээ ойрын хоёр, гурван жилдээ хойш нь тавьж байгаад.

Бусад хөрш зэргэлдээ орнуудын жишгийг харж байхад аль болохоор иргэддээ зээл өгч байж л эдийн засаг нь

хөдөлж байна шүү дээ. Би дээр ярьж л байсан. Хятадууд бараг л худлаа хэлсэн хүнд гарын үсэг зурж чаддаг болгонд нь зээл өгч байна л гэж хэлээд байсан. Яах вэ зүгээр хэтрүүлэгтэй байх.

Гэхдээ тэгж байж энэ хөгжил, энэ эдийн засагт орох орлого чинь нэмэгдэнэ. Иргэдийн ажилтай, орлоготой болохоор татвар нь дагаж нэмэгдэнэ. Бас нийгмийн даатгал нь нэмэгдэнэ гэх мэтчилэн энэ бүгдийгээ манай Сангийн яаманд анхаарч ажиллавал ямар байдаг юм бэ?

Тэгэхгүй ингээд төсөл, хөтөлбөр гээд явахаараа л буруутна шүү. Тэгээд тэр нь нэг хэсэг нь цаас болж хувирдаг. Ялангуяа гаднын зээл бараг тал нь цаасандаа, зураг төсөлдөө л алга болдог юм шиг байгаа юм. Хараад байхад. Тэгээд үүнийг бас бодолцоорой гэж хэлмээр байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Б.Баттөмөр гишүүн саналаа хэлье.

Б.Баттөмөр: Би 25 жилийн хугацаатай 2 хувийн хүүтэй гээд яг энэ утгаар нь дэмжиж байгаа юм.

Дотор талын задаргааг үзэхээр хармаар юм их байна шүү. Үүнийг Б.Жавхлан сайд доторх задаргааг нь сайн үзээрэй.

Яах вэ, гаднаас зээл аваад валютын нөөц дээр нэмэгддэг. Монгол төгрөгөөр дотоодод чиглэсэн энэ төсөвтэй холбоотой юмнууд нь явдаг ч гэсэн эцсийн эцэст зээл үр ашигтай л байх ёстой. Улсын Их Хурлаас Засгийн газарт чиглэл болгосон чиглэлд эдийн засгийн үр ашигтай чиглэлд л зээл авъя гэсэн ийм л юм явж байгаа шүү дээ.

Зүгээр дэлхийн хэмжээ ганц Монгол биш л дээ. 33.4 тэрбум долларын өртэй. Дэлхийн хэмжээнд хаа сайгүй л

хүнд байдаг бололтой. Сая Америкт болж байгаа үйл явдал. Өрийн хэмжээгээ таазаа нэмж байж дефолтоос сэргийлж байна шүү дээ. Түүнтэй адилхан манайд асуудлууд их байгаа.

Сүүлийн үед **“улсын өр”** биш **“төрийн өр”** гэж ярьдаг болсон шүү дээ. Олон улсын хэмжээнд. Манай 8.5 дээр своп хэлцлүүд байна, Хөгжлийн банкны зээл байна. Тэгээд дээрээс нь төрийн өмчтэй компаниудын зээл гээд ингэх юм бол нэлээн л том тоо гарна даа.

Тийм учраас энэ зээл дандаа хөгжил рүү л явмаар байна. Дотооддоо эдийн засгаа эрчимжүүлж, татвараа сайн хурааж, орлого олохоос гадна гаднын хөрөнгө оруулалтыг дэмжинэ. Хоёр дахь зам нь. Гурав дахь нь, гаднаас хямд эх үүсвэр, зээл авах ийм 3 гарц л байж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ зээлийг үр дүнтэй зарцуулья. Ер нь нэг тийм төсөл гээд л ирэхээр зэрэг нэг их том төслийн нэгж гэж байгуулаад л, их том том доллароор цалинжаад л ингээд явчихдаг байхгүй юу. Тэр зээл эцэст нь Монголын ард түмний татварын мөнгөөр л төлнө шүү дээ.

Тийм учраас төслүүдийн тэр хүн шунаад яваад байдаг зардлыг нь багасгах хэрэгтэй. Үр ашигтай болгох шаардлагатай. Үүнийг хэлэх гээд байгаа юм.

Хөгжлийн банкны ирээдүйг Б.Жавхлан сайд өнөөдрөөс эхлээд харах ёстой шүү. Бид өөрснөө монголчууд л сүйтгэчихсэн шүү дээ. Ямар ч бэлтгэлгүйгээр, төлөвлөгөөгүйгээр гаднаас их том 1.5 тэрбум долларын зээл авчраад л ямар ч үр ашиггүйгээр тэгээд л хуйвалдаад л тараачихсан.

Энд тэнд аваачаад хадгаламж хэлбэрээр байрлуулчихсан. Тэгээд энд

тэнд доллароор өгчхөөд нөгөө хүүгийн зөрүү гээд асар их хэмжээний алдагдал гарчихсан байж байгаа шүү дээ. Монголчууд өөрснөө л Хөгжлийн банкныг дампууруулчихсан байхгүй юу.

Тийм учраас би энэ Хөгжлийн банк Монголд байх ёстой. Монголын эдийн засагт тус нэмрээ үзүүлнэ.

Тийм учраас Хөгжлийн банкны ирээдүйг өнөөдрөөс эхлээд харах ёстой. Тэр хоёр юуных нь **“Самурай бонд”**-оо төлчихсөн. Нөгөө **“Евро бонд”**-оо одоо ингээд эх үүсвэрийг нь гаргаад төлөх ёстой байх.

Ингээд энэ Хөгжлийн банкныг ирээдүйг нь их сайн харах ёстой гэж бодож байгаа юм.

Тэгээд сая Б.Дэлгэрсайхан гишүүн ярьж байгаа. Одоо ерөөсөө Монголд энэ хувийн хэвшилд бага хүүтэй урт хугацаатай зээл хэрэгтэй. Монгол брэндүүдийг гаргаж ирэх ёстой.

Энэ ашигт малтмал болон бусад салбарт байгаа нэмүү өртөг шингээх энэ үйлдвэрлэлүүдэд зээлийг өгөх ёстой. Төрийн бодлогоор. Авчраад бүүр зуучлаад.

Одоо тэр компаниуд өөрснөө гүйгээд тэр зээлийг олж байх түвэгтэй л дөө. Тэгээд ийм ийм зүйлүүд дээр бид анхаарах шаардлага байна шүү.

Дахиад хэлэхэд юу гэхээр дотор талын задаргааг нь сайн үзээд үр ашигтай болгох чиглэлд манай Сангийн яам, холбогдох газрууд энэ дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Б.Энх-Амгалан: Н.Наранбаатар гишүүн үг хэлье.

Н.Наранбаатар: Сангийн яам, Зам, тээврийн яамныхан байгаа учраас сая тойрогтоо ажиллаж байхад иргэдийн нэг хэлээд байгаа зүйлийг бас хэлье. Ирэх оны төсөв ярихдаа бас бодолцоно биз гэж.

Өнгөрсөн жил өдийд Ерөнхий сайд манайд очсон. Засгийн газрынхаа нэлээн хэдэн гишүүдтэй. Тэгээд тэнд иргэдийн уулзалт дээр Даланзадгадаас Гурвантэс сум хүртэл 320 километр зам дээр 80 километр замыг улсын төсвийн хөрөнгөөр үргэлжлүүлэе. Бусдыг нь орон нутаг өөрөө хариуцаад дуусгачихъя гэдэг ийм зүйлүүд дээр зөвшөөрсөн байгаа.

Тэгээд сая очиход бас энэ асуудал юу болж байна гээд асууж байсан.

Ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд суугаагүй. Тэгэхдээ бас гаргалгаа байгаа. Аймгийн хувьд энэ жил 260 орчим тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлж байгаа. Ирэх жил мэдээж энэ буурахгүй байлгүй. Үүнээс илүү л төвлөрүүлэх байх.

Тэгэхээр Ерөнхий сайдын хэлсэн тэр 80 километр замын төсөв, санхүүжилтийг нь төвлөрүүлэх, энэ орлогоос нь үлдээгээд ингээд энэ замыг нь дуусгачих боломж байна уу, үгүй юу? Үүнийг судалж үзээч ээ.

Хэрвээ энэ зам ашиглалтад орчих юм бол манай аймгийн үндсэндээ алслагдсан баруун сумд бүгдээрээ. 4 сум байгаа. Холбогдохоос гадна Улаанбаатар, Шивээхүрэн боомт авто замаар холбогдох бололцоотой болж байгаа юм. Гашуунсухайт, Шивээхүрэн хоёр боомт маань хоорондоо авто замаар холбогдох бололцоо бүрдэх юм.

Аймаг 160 километрийг нь тавиад дууссан. Өөрийнхөө хөрөнгөөр. Үлдсэн хугацаанд 80 километрийг нь бас

өөрийнхөө хөрөнгөөр тавиад, үлдсэн 80-ыг нь улсын төсвөөр буюу улсад төвлөрүүлж байгаа орлогоосоо тавь гэдэг ийм хүсэлт тавиад байгаа юм. Үүнийг судалж үзээрэй гэж хүсье.

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайд үгээ хэлье.

Д.Цогтбаатар гишүүн үгээ хэлье. Д.Цогтбаатар гишүүний микрофоныг.

Д.Цогтбаатар: Би ганц минут. Сангийн сайдад хандаж бас нэг зүйл хэлмээр байна.

Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороонд 1.3 километр суваг, ус зайлуулах инженерийн байгууламж хийгдсэн байгаа юм.

Тэгээд тэр хийгдээд 90-хэн метр дутаад, саяын үнийн өсөлтөөс болоод төсөв нь хүрэхгүй зогсчихсон байгаа юм.

Тэгээд үүнийг бас нэг талдаа гаргаж шийдэж өгөхгүй бол ахиад л өчнөөн хөрөнгө оруулалт хийгээд ажил нь хийгдчихсэн. 90 хувь нь үр ашиггүй болчихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр 90 метр дээр гүйцээх төсвийг нь тавьж өгөх тал дээр, эсвэл үүнийг нь яаж шийдэх вэ? Сангийн би сайд энэ дээр нэг анхаарч өгөөч. Тэгвэл би бас энэ дээр хоттой ярих юман дээр нь би хөөцөлдөж ярья. Тэгээд үүнийг урагшлуулахгүй болохгүй байна.

Яагаад гэвэл одоо яг сезон. Тэгээд энэ 8 сар гээд аягүй үер ус эхэлнэ. Маш олон айлуудад амаргүй нөхцөл байдал бас үүснэ шүү. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хуулийн төсөлтэй холбогдуулаад гишүүд үг хэлж дууслаа.

Гишүүдийн хэлж байгаа саналуудыг ажлын хэсгийнхэн, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Зам, тээврийн яамныхан тэмдэглэж аваарай.

Эдийн засгийн үр ашигтай төслүүдэд энэ мөнгийг зараарай гэж хэллээ шүү. Протоколд тэмдэглэгдлээ.

Ингээд санал хураалт явуулж эхэллээ.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн санал хураалтад оролцсоноос 8 гишүүн дэмжиж, 80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, 17 цаг 27 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД